



**ЗАВХАН АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 03

Улиастай

Дотоод аудит хийсэн дүнгийн тухай

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Шалгалтын удирдамж, үндэслэл:

Албаны 2022 оны Дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргын 2022.01.07-ны өдрийн 06 дугаар удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Чадраабал дотоод аудит хийж, гүйцэтгэлээ.

1.2 Дотоод аудитын хүрээ:

Улиастай сумын 9-р Цэцэрлэгийн 2020-2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, холбогдох хууль, эрх зүйн хэрэгжилт хамрагдсан.

1.3 Шалгалтын явцад хийсэн ажил, үр дүн:

Удирдамж, төлөвлөгөөг албан тушаалтан нарт танилцуулж удирдамжид тусгагдсан асуудлуудыг анхан шатны баримт, бүртгэлтэй тулган үзэж Дотоод аудитын дүнг удирах болон санхүү, мөн дотоод хяналт хариуцсан ажилтан нарт танилцуулж тэдний санал хүсэлтийг сонсож, засаглах удирдлага, дотоод хяналт, эрсдэлийн үнэлгээ зэргээр асуулга авч дүгнэлт гаргалаа.

Хоёр. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал.

- Тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах, зорилго, зорилт тодорхойлох үйл явцад засаглах удирдлага оролцдоггүй нь тус байгууллагын дэвшүүлсэн зорилго биелэх магадлал бага уриа, лоозон шинжтэй байна.
- Дотоод хяналтын үр нөлөө, ач холбогдол бага
- Эрсдэлийн удирдлагын талаар ойлголтгүй

Гурав. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал.

- Материалын орлогын баримт нягтлан бодогчийн гарын үсэг, тэмдэгээр баталгаажуулаагүй, байгууллагын тамга дарсан
- Эд хариуцагчийн материалын тайланг нягтлан бодогч хянаж баталгаажуулаагүй.
- 2021.01-05 сард онцгой байдлын үед өгсөн 9535.8 мянган төгрөгийн хүнсний материалын зарцуулалтын тайланг эрхлэгч Ш.Болормаа гарын үсэг зурж хянаагүй, гарын үсгийг дуурайлган зурах гэж оролдсон байгаа нь зориулалт бусаар зарцуулагдсан байх магадлалтай.
- Эрхлэгч нарын ур чадварын нэмэгдэл, урамшуулалт цалингаас ХХОАТ, НДШ суутган тооцоогүй.
- Эрхлэгч Ш.Болормаа эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй сарын цалин, амралтын цалин давхардуулан авсан
- Ажилтанд тушаал шийдвэргүй ур чадварын нэмэгдэл олгосон
- Иргэдээс худалдан авсан материалын үнээс ХХОАТ суутган тооцоогүй.

Дөрөв. Шийдвэрлэсэн нь.

1. Хууль, тогтоомж хэрэгжүүлээгүйтэй холбоотойгоор 3581971 төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоолоо.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ Б.ЧАДРААБАЛ

